

БАТЛАВ
НИЙТЛЭГ ҮЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2018 оны сарынөдөр

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2018 оны 10-р сарын 01 өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго:

НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалд хяналт-шинжилгээ хийж, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ:

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд

3. Хугацаа:

2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрүүдийн хооронд

4. Ажлын хэсэг:

Дотоод хяналт-шинжилгээ,
үнэлгээний ажилтан

Т.Итгэл

Их эмч

Н.Энхзаяа

Тооцооны нягтлан бодогч

П.Ариунцэцэг

5. Хяналт-шинжилгээ хийх чиглэл:

5.1 Хяналтын хуудасны асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ хийх;

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, түүний мөрдөлтөнд хяналт тавих;

5.3 Шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

6. Бусад:

6.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, асуулга явуулах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

6.2 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

6.3 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр хяналт-шинжилгээ хийж, аливаа дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай саналыг боловсруулж, газрын даргад танилцуулна.

**НЗЗ-НЫ БАЙРУУД, НҮНТ-ИЙН САЛБАРУУДЫН ЦЭВЭРЛЭГЭЭ,
ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

ИЛТГЭХ ХУУДАС

2018 оны 10 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт шинжилгээ хийх ажлын хэсэгт их эмч Н.Энхзаяа, тооцооны нягтлан бодогч П.Ариунцэцэг, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар ажилласан ба 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд хяналт шинжилгээг хийлээ.

Ажлын хэсэг тус газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам”, “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага” CS 11-0256:2014 стандартыг тус тус удирдлага болгон ажиллалаа.

НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5 дугаар байр, НҮНТ-үүдэд тус тус ажиллан, хяналтын хуудасны 7 шалгуур үзүүлэлтийн хүрээнд оноогоор дүгнэж, гүйцэтгэлийн хувийг гаргасан. Гүйцэтгэлийн хувийг нэгтгэж хүснэгтээр харуулав.

Шалгуур үзүүлэлт	НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбарууд								Шалгуурын дундаж гүйцэтгэл
	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр	Дүнжингарав салбар	Мишээл салбар	Драгон салбар	
	Гүйцэтгэлийн хувь								
Байруудын цэвэрлэгээний чанар	84	84	34	75	50	92	50	45	64.3
Халдваргүйтгэл хуваарийн дагуу хийдэг эсэх	100	100	78	78	84	100	92	92	90.5
Хорхой, шавж, амьтан байгаа эсэх	75	100	84	84	84	42	100	9	72.3
Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан байдал	79	72	82	82	65	96	58	63	74.6

Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдал	86	93	86	96	72	100	72	58	82.9
Цэвэрлэгээний материалын эмх цэгц, цэвэр байдал	89	84	89	97	84	97	64	45	81.1
Цэвэрлэгээ үйлчилгээнд гарсан гомдол санал	100	100	94	94	100	100	100	100	98.5
Байруудын дундаж гүйцэтгэл	87.5	90.4	78	86.5	77	89.5	76.5	58.8	80.6

Дээрх хүснэгтээс харахад:

НЗЗ-ны 2 дугаар байр 90.4%-ийн гүйцэтгэлтэй буюу бүрэн хангалттай үнэлгээтэй, НҮНТ-ийн Дүнжингарав салбар 89.5%, НЗЗ-ны 1 дүгээр байр 87.5%, 4 дүгээр байр 86.5% буюу тус тус хангалттай үнэлгээтэй байсан бөгөөд НЗЗ-ны 3 дугаар байр 78%, 5 дугаар байр 77%, НҮНТ-ийн Мишээл салбар 76.5% буюу тус тус ажил сайжруулах шаардлагатай, НҮНТ-ийн Драгон салбар 58.8 буюу хангалтгүй үнэлгээ авсан байна.



Үйлчилгээний албаны цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйтгэлийг шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд цэвэрлэгээ үйлчилгээнд гарсан гомдол санал 98.5%, халдваргүйтгэл хуваарийн дагуу хийдэг эсэх 90.5% буюу тус тус бүрэн хангалттай, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдал 82.9%, цэвэрлэгээний материалын эмх цэгц, цэвэр байдал 81.1% буюу тус тус хангалттай бөгөөд багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан байдал 74.6%, хорхой, шавж, амьтан байгаа эсэх 72.3% буюу ажил сайжруулах шаардлагатай, байруудын цэвэрлэгээний чанар 64.3% буюу хангалтгүй үнэлгээтэй тус тус дүгнэгдсэн байна.



Хяналт шинжилгээ хийх явцад:

Ажлын хэсэг ажиллах явцад ажилтан, албан хаагчдаас гаргасан ноцтой зөрчил, дутагдал байхгүй бөгөөд байруудад ариутгал, халдваргүйтгэл хуваарийн дагуу хийгдэж, цэвэрлэгээ үйлчилгээнд гарсан гомдол саналгүй, хөдөлмөр хамгааллын зөрчил дутагдалгүй ажиллаж байгаа боловч зарим зөрчил дутагдлыг тухай бүр нь байр хариуцсан менежер, ажилтнуудад танилцуулж, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгсөн. Тухайлбал:

- Байруудад их цэвэрлэгээ, өндрийн цэвэрлэгээг чанаржуулах;
- Цэвэрлэгээний алчууруудад ялгах тэмдэглэгээ хийх;
- Зарим байрны гадна талбайн үйлчлэгч хүрз, цас цохигч, дэрсэн шүүр зэрэг багаж хангалтгүй;
- Дээврийн цэвэрлэгээ хийхдээ хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг бүрэн хангах;

Ажлын хэсгийн гишүүд ажилтан албан хаагчдын ур чадварыг дүгнэх явцдаа НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдэд ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас цэвэрлэгээ үйлчилгээний чанарын талаар асууж, санал хүсэлтийг сонсоход цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгаагаа хэлж байсан.

Мөн НҮГ-ийн үйлчилгээний ажилтнуудаас зарим санал, хүсэлтийг гаргасан.

- Цэвэрлэгээний алчуур ус авдаггүй тухай
- Хүн хүчний хүрэлцээ муу /НЗЗ-ны 3-р байр, НҮНТ-ийн Драгон салбар/
- Нийслэлийн Үйлдвэр Инновацын газар нь амархан бохирддог, өглөө ажилдаа ирэхэд маш их хогтой, шалны дроз дээр юм их асгасан байдаг цэвэрлэхэд хүндрэлтэй байдаг. Үйлчлэгч нарыг 2 ээлжээр ажиллуулах хүсэлтэй байгаа тухай
- НЗЗ-ны 5 дугаар байрны “В” корпусын хурлын заалны тоосыг соруулахад шаардлага хангасан, овор хэмжээ бага тоос сорогч хэрэгцээтэй тухай
- Халуун усгүй тул цэвэрлэгээ хийхэд хүндрэлтэй /НЗЗ-ны 5-р байрны “В” корпус, НҮНТ-ийн Оргил салбар/

Үйлчилгээний албаны цэвэрлэгээ үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалд хийсэн хяналт шинжилгээгээр 80.6% буюу хангалттай үнэлгээтэй дүгнэгдлээ.

Цаашид авах арга хэмжээ:

Хяналт-шинжилгээ хийсэн ажлын хэсгээс үйлчилгээний албаны дарга Л.Уранхайчид дараахь үүрэг даалгаврыг өгч, биелэлт, үр дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тайлагнахыг үүрэг болгов. Үүнд:

- Хангалтгүй үнэлгээ авсан:

НҮНТ-ийн Драгон салбар

- Цэвэрлэгээний чанарыг сайжруулах;
- Хорхой, шавжны устгал хийх;
- Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- Цэвэрлэгээний материалын эмх, цэгц, цэвэр байдлыг хангаж ажиллах;

- Ажил сайжруулах шаардлагатай үнэлгээ авсан:

НЗЗ-ны 3, 5 дугаар байр, НҮНТ-ийн Мишээл салбар

- Цэвэрлэгээний чанарыг сайжруулах;
- Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах

- Хангалттай үнэлгээ авсан:

- НЗЗ-ны 1, 4 дүгээр байрууд, НҮНТ-ийн Дүнжингарав салбар тус хяналт-шинжилгээгээр дүгнэгдсэн үнэлгээг улам ахиулан ажиллах;

- НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон үйлчилгээний ажилчдаас гаргасан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах;

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ИХ ЭМЧ

Н.ЭНХЗАЯА

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНЦЭЦЭГ